



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 03 өдөр

Дугаар A/444

Зуунмод

Г Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн хэмжээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар зам тээврийн осол гэмт хэрэг өссөнтэй холбогдуулан Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдэлийг бууруулах зорилгоор 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Нэгдсэн арга хэмжээнд шаардлагатай 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг аймгийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” арга хэмжээний төлөвлөгөө гарган үр дүнтэй зохион байгуулж, олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

Б.Одшиг  
Сүхнүү

Х.Делс

04/нн,